

ТАНИЛЦУУЛГА

*Цахим гарын үсгийн тухай
хуулийн шинэчилсэн найруулгын
төслийн талаар*

Цахим гарын үсгийн тухай хууль нь 2011 онд батлагдсан, 6 бүлэг, 36 зүйлтэй. Уг хуульд батлагдсанаас хойш 3 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нийт 3 зүйл, заалтад өөрчлөлт орсон. Энэ хуулиар цахим болон тоон гарын үсэг хэрэглэх эрх зүйн үндсийг тогтоож, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулж байна. Өөрөөр хэлбэл нийтийн түлхүүр ашиглан мэдээллийг шифрлэн хувиргаж, түүнд хамааралтай хувийн түлхүүрээр мэдээллийг задлах, эсрэгээр мэдээллийг хувийн түлхүүрээр шифрлэсэн бол зөвхөн түүнд хамааралтай нийтийн түлхүүрээр задлах зарчмаар ажиллах нийтийн түлхүүрийн дэд бүтцийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын дэргэд байгуулж, иргэн, хуулийн этгээдийг цахим хэлбэрээр таньж, баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээг тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд олгодог бөгөөд 2015 онд “Мон Пасс” ХХК, 2018 онд “Тридиум и-Секюрити” ХХК, “ВиЭсЭм” ХХК, “Нью компас” ХХК гэсэн 4 байгууллага Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл авч, нийт 2021 оны 3 сарын байдлаар 30399 тоон гарын үсгийн гэрчилгээг иргэн, хуулийн этгээдэд олгосон байна. Харин “Үндэсний дата төв” УТҮГ-аас 8008 төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээг олгосон хэдий ч одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар тус байгууллагад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох эрх олгогдоогүй байна.

Энэ хуулийг баталснаас хойш 9 жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдэд нийт 38407 тоон гарын үсэг олгогдсон байгаа нь практикт тус хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгааг бодитойгоор харуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр олгосон тоон гарын үсгийн ихэнх нь аж ахуйн нэгж, байгууллагад олгогдож, иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгох ажил ихээхэн удаашралтай байгаа юм. Гадаадын улс орнуудын туршлагаас харахад тухайлбал, Европын холбоо 1999 онд “Цахим гарын үсгийн удирдамж”-ийг баталж, 2014 онд зохицуулалтыг шинэчлэн, 2016 оноос холбооны бүх улсуудад хэрэгжиж эхэлсэн “Цахимаар таних болон Итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS No 910/2014)-ын зохицуулалтаар хувь хүн, хуулийн этгээдийг цахим орчинд таних нөхцөлийг бүрдүүлэх, цахим гарын үсэг, цахим тамга, цахим цагийн бүртгэл, цахим баримт бичиг, цахим гүйлгээний журам зэргийг жишиг болгон тогтоож, Европын холбооны гишүүн улс орнууд тоон гарын үсэг хэрэглэхдээ дагаж мөрдөж байна.

Мөн Эстони Улс нь дээр дурдсан Европын холбооноос баталсан журмыг жишиг болгон дагаж мөрдөхөөс гадна 2000 онд баталсан Тоон гарын үсгийн тухай хуулиар тоон гарын үсэгтэй холбоотой харилцааг зохицуулж, хуулийн этгээд бүртгүүлэх, банк, санхүү, сонгууль, татварын бүртгэл хийлгэх зэрэг гарын үсэг шаардаж байгаа аливаа үйлчилгээг төрийн байгууллагаас цахим хэлбэрээр авахад болон бусад үйлчилгээнд 2021 оны байдлаар 900 саяаас дээш тооны тоон

гарын үсгийг хэрэглээнд гаргасан гэсэн тоон мэдээлэл байна. Ингэхдээ тоон гарын үсгийг тохиромжтой гэж үзсэн хэрэгсэл буюу иргэний үнэмлэхийн санах ой, гар утасны сим картанд тоон гарын үсгийг байршуулах, Эстони дахь баталгаажсан Smart-ID болон digi-ID зэргийг ашиглан олгодог байна.¹

Иймд Цахим гарын үсгийн тухай хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх, практикт үүсээд байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх замаар цахим орчинд цахим гарын үсгийг ашиглан үйл ажиллагаа явуулах боломжийг сайжруулж, түүний хэрэглээг нэмэгдүүлж хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу уг хуулийг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэн Цахим гарын үсгийн тухай хуульд зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орсноос гадна хуулийн нийт зүйл, заалтын талаас илүү хувьд буюу 34 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийг орууллаа. Үүнд:

1.Цахим гарын үсгийн тухай хуулийн зорилтыг өөрчилж, цахим орчинд хүн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэх, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлагыг тогтоох талаар нэмж тусгасан.

2.Хуулийн үйлчлэх хүрээг тогтоохдоо төрийн болон албаны нууцад хамааруулснаас бусад мэдээллийг цахим орчинд иргэн, хуулийн этгээд хооронд дамжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд “албаны нууцад” гэснийг хасаж тогтоосон. Өөрөөр хэлбэл одоогийн зохицуулалтаар албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулахад энэ хууль үйлчлэхгүй байхаар заасан нь хуулийн үйлчлэх хүрээг ихээхэн хумьсан шинжтэй зохицуулалт үйлчилж байна. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт зааснаар албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батлахаар заасны дагуу байгууллагууд албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хэт өргөн хүрээнд гаргах тохиолдол байсаар байгаа нь төрийн байгууллагын хэмжээнд тоон гарын үсэг хэрэглэн дамжуулж болох мэдээ, баримт бичгийг албаны нууцад хамааруулсан гэдэг үндэслэлээр хасаж байна. Нөгөө талаар албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулахад нууцлал алдагдах эрсдэлээс сэргийлж байгаа гэх боловч гэрчилгээгээр баталгаажсан тоон гарын үсэг хэрэглэн цахим орчинд хүн, хуулийн этгээд нь өөрийгөө батлах, цахим өгөгдлийг аюулгүй дамжуулах, хүлээн авах, харилцагч талуудын хооронд итгэлцэл бий болгох, эх сурвалжийг баталгаатай тодорхойлох боломжтой болсныг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсад тоон гарын үсгийн хэрэглээтэй холбоотой маргаан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэгдээгүй байна.² Өнөөгийн байдлаар мөн Монгол Улсын шүүхийн

¹ <https://e-estonia.com/solutions/e-identity/>

² А.Мөнхзул, “Цахим гарын үсэг зурах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах тухай”, Монголын төр, эрх зүй №1 (2014): 26 дахь тал.

шийдвэрийн цахим сан /shuukh.mn/-аас тоон гарын үсэгтэй холбоотой маргаан хэлэлцэж шийдвэрлэсэн шийдвэр олдоогүй. Ерөнхийдөө тоон гарын үсгийг хуурамчаар үйлдэх боломжгүй хамгаалалт сайтай, зурагдсан тоон гарын үсэг болон түүнд хавсаргасан буюу нэгтгэсэн мэдээ, баримт бичигт өөрчлөлт орсон эсэхийг тогтоох боломжтой гэж үздэг байна. Тэгвэл ердийн гарын үсгийг хэн ч дуурайлган зурах боломжтой ба гарын үсгийн тусгай криминалистик шинжилгээгээр дууриалгасан эсэхийг тогтоодог хэдий ч зарим тохиолдолд тогтооход ч хүндрэлтэй байдаг, аюулгүй байдлын хамгаалалт байхгүй гэж үздэг байна.³

3.Тоон гарын үсэгт тавигдах шаардлагыг тодорхойлж, хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчийг нийтийн түлхүүр ашиглан таних, шалгах боломжтой, мэдээлэлд тоон гарын үсгийг хавсаргасан, эсхүл нэгтгэсний дараа мэдээлэл болон тоон гарын үсэгт өөрчлөлт оруулсан, мэдээллийн бүрэн бүтэн эсэхийг мэдэх боломжтой байхаар тогтоосон. Түүнчлэн төрийн албан хаагч иргэний хэрэглэх тоон гарын үсгээс гадна төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ тоон гарын үсэг хэрэглэж болохоор тусгалаа.

4.Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсэг хэрэглэхээр заасныг өөрчилж, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тоон гарын үсэг, хуулийн этгээд цахим тамга хэрэглэхээр тусгалаа. Ингэхдээ Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн бүрт тоон гарын үсгийн гэрчилгээг үнэ төлбөргүй олгож, түүний иргэний үнэмлэхийн санах ойд тоон гарын үсэг хэрэглэхтэй холбоотой мэдээллийг байршуулахаар зохицууллаа. Мөн хүн, хуулийн этгээд тоон гарын үсэг, цахим тамга хэрэглэхээс гадна хүн, хуулийн этгээдийн хэрэглэх бусад цахим гарын үсгийн тоо, хэлбэрт хязгаар тогтоохгүй байхаар заасан.

5.Тоон гарын үсэг, цахим тамга нь гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон тоон гарын үсгийн гэрчилгээтэй байхаар, гэрчилгээнд тусгавал зохих мэдээлэл, гэрчилгээний хүчинтэй байх хугацаа, гэрчилгээний үнэ, гэрчилгээний мэдээллийн сан, гэрчилгээ эзэмшигчийн талаарх зохицуулалтыг цогц байдлаар тусгасан. Өөрөөр хэлбэл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Цахим гарын үсгийн тухай хуулиар гэрчилгээний хүчинтэй хугацааг ихдээ 2 жил хүртэл байхаар иргэн, хуулийн этгээдэд олгох гэрчилгээний хугацаанд ямар нэгэн ялгаа тогтоолгүй олгож, тэр бүртээ гэрчилгээний үнэ буюу тоон гарын үсэг болон тоон гарын үсгийн хэрэгсэл, үйлчилгээний хөлс авч байна. Иймд уг зохицуулалтыг өөрчилж гэрчилгээг иргэнд 5 жил, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдэд 3 жил хугацаагаар олгохоор тус тус зохицуулсан. Түүнчлэн гадаадын иргэн хүсэлт гаргаж тоон гарын үсэг авч болох зохицуулалтыг шинээр тусгаж, түүний оршин суух хугацаагаар, эсхүл 5 жилээс дээш хугацаагаар оршин суух бол гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгохоор орууллаа.

6.Хуулийн төсөлд гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах, хүсэлтэд ямар мэдээлэл тусгах, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар журамласан зохицуулалт байхгүй байсныг шинэчлэн иргэн улсын бүртгэлийн байгууллагад, хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тусгай зөвшөөрөл

³ Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 2021 он

эзэмшигчид гаргахаар, ирүүлсэн хүсэлтийг эдгээр байгууллага хүлээн авч иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл үнэн зөв, бичиг баримт нь хүчинтэй эсэхийг шалгасны үндсэн дээр гэрчилгээ олгох, эсхүл хүсэлт гаргагчийн мэдээлэл зөрүүтэй бол хүсэлтийг хүсэлт гаргагчид буцаахаар, гэрчилгээ олгосны дараа хуульд заасан үндэслэлээр гэрчилгээг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохоор тусгасан.

7.Гэрчилгээжүүлэх байгууллагад Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс гадна Улсын бүртгэлийн байгууллагыг шинээр нэмж тусган, эдлэх эрх, хүлээх үүрэг, гэрчилгээ олгохтой холбогдуулан өөрийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, хуульд заасан зарим мэдээллийг нийтэд ил болгох үүрэг хүлээж, гэрчилгээ авах, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар хүсэлт гаргагчийн гаргасан хүсэлтийг хүлээн авах, холбогдох мэдээллийг шалгасан талаар бүртгэл хөтөлж, бүртгэлийг хадгалах, мэдээллийн сан бүрдүүлэхээр тусгалаа.

8.Гэрчилгээ түдгэлзүүлэх, сэргээхтэй холбоотой одоогийн зохицуулалтыг шинэчлэн олон улсын жишигт нийцүүлээ. Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тоон гарын үсгийн гэрчилгээг олгож, уг гэрчилгээг түдгэлзүүлэхдээ тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Зөрчил илэрсэн, гэрчилгээ эзэмшигчийн хүсэлтээр маргааныг хянаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөрчлийг шалгаж, арилгах хүртэл гэрчилгээг түдгэлзүүлж, зөрчил арилснаар гэрчилгээг сэргээнэ.” гэж заажээ. Энэ заалтад илэрсэн зөрчлийн талаар тодорхой заагаагүй тул тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай компаниуд гэрчилгээжүүлэх бодлого/гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журмын дагуу зөрчил илэрсэн, илрээгүйгээс үл хамааран тоон гарын үсгийн гэрчилгээг гэрчилгээ эзэмшигчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу түдгэлзүүлж байна.

Тэгвэл гэрчилгээг түдгэлзүүлэх асуудлыг гадаад улс орнууд хэрхэн зохицуулж байгааг судалж үзэхэд Эстони, Израйль, Турк зэрэг улс орнууд гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг түдгэлзүүлэх талаар хүсэлт гаргасан, гэрчилгээнд тусгасан мэдээлэл алдаатай, эсхүл хувийн түлхүүрийн нууцлал алдагдсан гэж гэрчилгээжүүлэх байгууллага үзсэн, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчилгээг түдгэлзүүлэх талаар шийдвэр гарсан зэрэг үндэслэлээр түдгэлзүүлж, гэрчилгээжүүлэх байгууллага гэрчилгээг түдгэлзүүлсэн тухай гэрчилгээ эзэмшигчид даруй мэдэгдэх талаар үүрэг хүлээлгэдэг байна. Түүнчлэн гэрчилгээг сэргээх талаар тусгахдаа түдгэлзүүлсэн үндэслэлээс шалтгаалан өөр өөр нөхцөлөөр сэргээдэг байна. Тухайлбал, гэрчилгээг түдгэлзүүлэх талаар хүсэлт гаргасан гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг сэргээх тухай хүсэлт гаргаснаар гэрчилгээг сэргээх, эсхүл гэрчилгээг гэрчилгээнд тусгасан мэдээлэл алдаатай, хувийн түлхүүрийн нууцлал алдагдсан гэж гэрчилгээжүүлэх байгууллага үзэн гэрчилгээг түдгэлзүүлсэн бол энэхүү түдгэлзүүлсэн шалтгаан арилсан тохиолдолд гэрчилгээжүүлэх байгууллага сэргээж байхаар ялгамжтай зохицуулсныг хуулийн төсөлд тусгалаа.

9.Гадаад улсын гэрчилгээг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх тохиолдлыг гадаад улс орнуудын жишигт нийцүүлэн өөрчилж, гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллага нь энэ хууль, холбогдох журамд заасан шаардлагыг хангаж байгаа

талаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарсан, Монгол Улстай байгуулсан олон улсын гэрээгээр гадаад улсын гэрчилгээжүүлэх байгууллагын гэрчилгээг хүлээн зөвшөөрсөн байх нөхцөлүүдийг тусгалаа.

10.Гэрчилгээ олгох үйл ажиллагааг харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх, уг зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа компанид олгох зэрэг суурь зохицуулалтыг хэвээр үлдээж, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хүчингүйд тооцох, тусгай зөвшөөрөл эзэмшигчид хориглох зүйлийн талаарх зохицуулалтыг илүү ойлгомжтой байлгахаар найруулгын шинжтэй өөрчлөлтүүдийг орууллаа.

11.Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан нэр томьёог жигдлэх зорилгоор Иргэний хуульд, хуулийн хэрэгжилтийг хангах талаар Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад материалыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны www.mojha.gov.mn сайтад байршуулсан бөгөөд иргэн, хуулийн этгээдээс санал ирүүлээгүй болно.

---o0o---